





ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2025 ОНД АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН ЁС ЗҮЙН
СУРГАЛТ, НӨЛӨӨЛГИЙН АЖЛЫН ТАЙЛАН

№	Төлөвлөгөөт арга хэмжээ	Биелэлт	Хугацаа	Хамрагдсан албан хаагчийн тоо	Зураг
1	Байгууллагын ёс зүйн хэм хэмжээний дүрэм, журмыг танилцуулах	Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолыг үндэслэн Аймгийн Засаг даргын 2023 оны А/845 захирамжаар Худалдан авах ажиллагааны газрыг 10 хүний бүтэц орон тоотойгоор байгуулж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын Ёс зүйн дэд хороог 2024.04.05-ний өдрийн А/07 тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, газрын ёс зүйн дүрмийг баталсан. Ёс зүйн дэд хорооны гишүүн ажлаас чөлөөлөгдсөн тул газрын даргын 2025.08.13-ний өдрийн А/12 тушаалаар Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна.	2025.01.01- 2025.10.01	8	

2	Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган баталж 10 сарын байдлаар дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. ✓ “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтыг албан хаагч нарт 2025.02.05-ний өдөр зохион байгуулсан. ✓ Сар бүрийн 3 дахь Даваа гарагт “Ёс зүйн зөвлөгөө өгөх өдөр” болгон хэвшсэн. ✓ Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулсан. ✓ Ажлын ачаалал, стрессийг хэрхэн даван туулах вэ сургалтыг хөгжөөнт тоглоом хэлбэрээр зохион байгуулсан. ✓ Байгууллагын соёлыг төлөвшүүлэх хамт олны уур амьсгал, төрийн албан хаагчийн харилцааны соёл ёс зүйн мэдлэгийг дээшлүүлж чадавхжуулах зорилгоор Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүйн тухай сургалтыг 2025.07.25-ны өдөр 1 цагийн хугацаанд 7 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.	8	2025.01.01-2025.10.01	8
----------	--	--	----------	------------------------------	----------



Байгууллагад шинээр орсон албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журам танилцуулах	2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар шинээр Худалдан авах ажиллагааны газарт шинээр ажилд орсон нягтлан бодогч, дотоод хяналт, шалгалт хариуцсан 2 албан хаагчид Байгууллагын зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагын дотоод журмыг танилцуулсан.	2025.05.01- 2025.08.11	2 
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх мэдээлэл түгээх	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт 2 цагийн сургалтад бүх албан хаагчиг хамруулсан. Тус сургалтаар Авлигын тухай ойлголт, хор хөнөөл ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам, болон Нийтийн албан тушаалтны хориглолт хязгаарлалтын талаарх мэдээллийг өгсөн.	2025.06.03	8 

5	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, бусад эрх зүйн баримт бичгийг сурталчлах, танилцуулах	2025 онд газрын бүх албан хаагч нарт 3 гарын авлагыг бэлтгэж мэдээ, мэдээлэлээр ханган ажиллаа. 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, 2. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, 3. "Ажлын байрны ёс зүй" гарын авлага	2025.01.01-2025.10.01	8	
6	Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах	Төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор, 7 дугаар 25-ны өдрөөс эхлэн Сар бүрийн 3 дахь Даваа гарагт "Ёс зүйн зөвлөгөө өгөх өдөр" болгон хэвшиж дараах сэдвүүдээр сургалт, илтгэл ярилцлага хийж хэвшсэн.	2025.01.01-2025.10.01	8	

